

Эртний монгол хаадын дипломат харилцааны
захидлуудын огноо

Ж. Лувсандорж
(Карлын Их сургууль)

Энэ өгүүллийн зорилго нь эртний монгол хаадын дипломат харилцааны захидлуудад тавьсан огнооны нэг ойлгомжгүй нэр томъёог тайлбарлахад оршино. Тийм захидлын жишээ нь Ил хан Агун (1289), Öljeitü (1305) нараас Францын ван Гоо Филиппт илгээсэн захидлууд¹ юм. Эхний захидлын огноо нь *Üker jil junu terigün sara- yin jirγuyan qaučid-ta* (букв. Год Коровы летнего первого месяца, шестое старое) гэсэн ба дараахи нь *Moγai jil junu terigün sara -yin naiman qaučid-ta* (букв. Год Змея летнего первого месяца, восьмое старое) гэсэн байдаг. Энд гарч буй *qaučid* гэдэг үг бол сонгодог монгол бичигт *qaučid* гэж бичдэг, хуучин гэдэг үгийн олон тоот хэлбэр мөн. Монголын уламжлалт зурхайн цаглавруудад болон тайлбар толиудад 29-30 хоногийг нэгэн сар болгож аливаа сарын 1-10-ныг хүртэлхи өдрүүдийг *sara-yin sined* (новолуние), 20-30-ныг хүртэлхи өдрүүдийг *sara- yin qaučid* (старолуние) гэж нэрлэдэг. Энэ ёсоор аливаа сарын зургаан, найманы өдөр нь *sara- yin sined* гэдэг нэр томъёотой холбогдох ёстой байтал *sara- yin qaučid* гэдэг нэр томъёотой холбогдсон нь судлагчдад "хатуу ааруул" болсон юм.

Сарын эхний өдрүүдийг *qaučid* гэдэг үгтэй холбосон огноо дипломат захидлуудад төдийгүй 13-р зууны үеийн монгол хаад ноёдын албан бичгүүдэд олон гардаг. Акад. Л.Лигеттийн *Monuments préclassiques 1, XIII^e et XIV^e siècles* хэмээх эмхэтгэлд орсон 26 баримт бичгийн 14 нь *sara- yin ... qaučid-ta* гэсэн огноотой байгаагаас үзвэл эдгээр өдрүүд бол эртний монголчуудын албан бичиг тамгалах ёр бэлгэтэй өдөр байсны баримт юм. Сельжүк эмир ноён Nūr ad Dīn өөрийн үр ач нарт үлдээсэн гэрээс бичигтээ бас *junu terigün sara-yin qoyar qaučid-ta*² гэсэн огноог сонгон авсан нь санамсаргүй тохиол биш биз. Сарын хуучид гэдэг өдрүүд бол эртний монгол цаглаварт бичиг баримт өргөн барих, тамгалах эрхэм сайн өдөр гэсэн заалттай байсан бололтой. Хожуу үеийн төвөд гаралтай монгол цаглаварт тийм заалттай өдрүүд байдаг³ боловч сарын шинэд, хуучидтай хамаагүй болчихжээ.

Эртний монгол хаадын бичиг захидлуудыг орчуулан тайлбарласан эрдэмтэдийн судалгаанаас үзвэл *junu terigün sara -yin naiman qaučid-ta* гэсэн огноог акад. Я. Шмидт: "1-го летнего месяца, 8-го старого числа"⁴ гэв. Монголын эртний он тооллын цаглаварт хуучин тоолол (старое число/старый стиль), шинэ тоолол (новое число/новый стиль) гэсэн нэрлэлт байхгүй болохоор энэ орчуулга тохирохгүй байна. Эл бичгийн *qaučid* гэдгийг Котвич "сарын гуравдугаар арав хоног (*La troisième décade de la lunaison*)"⁵ гэж тайлбарласнаар бол уг бичгийн

¹ Ligeti Louis 1972, *Monuments...*, p. 245-247, 252-255.

² Ligeti Louis, 1972, *Monuments...*, p. 270.

³ Цэдэнбал Я., 1999-2000, тал 106.

⁴ Үз Ключкин И.А., 1926, с.25.

⁵ Үз Ligeti Louis, 1972, *Fragments...*, p. 150.

огноо Зуны тэргүүн сарын гуравдугаар декадын найман буюу 28-ны өдөр болно. Гэвч сарыг гурван арав хоногоор хуваан тоолох ёс монголд байгаагүй тул түүний тайлбар бас тохирохгүй байна. Л. Лигети Берлиндхи Турфаны цуглуулгын Т1 (U5361) тоот эртний монгол баримтын огноонд буй "өвөлийн эхэн сарын *"arban qaγučin-a"* гэдгийг франц хэлээр "хуучин арван" (*le dix „vieux"*)⁶ гэж үгчлэн орчуулсан нь бас буруу утгыг өгч байна. Тийм үгчилсэн орчуулгыг бас И. А. Клюкин хийв. Тэр "летнего (*junu*) первого (*terigün*) месяца (*sara-yin*) восьмого (*naγman*) старого дня (*qaγučin-ta*)"⁷ гэж эхлээд үгчлэн орчуулсны дараа уг захидлыг бүрнээр нь орос хэлэнд орчуулахдаа "8-ого числа первого летнего месяца (зуны тэргүүн сарын найманд)" гэв. Тийнхүү И. А. Клюкин *qaγučin* гэдэг үгийг ойлгомжгүй тул орчуулалгүй орхив.

Хожим акад.Ц. Дамдинсүрэн тэр бичгийг одоогийн монгол хэлэнд хөрвүүлэхдээ Клюкинийг дагаж *qaγučin* –ыг орхиод "зуны эхэн сарын найманд"⁸ гэж бичив. Энэ бүхнээс үзэхэд эртний *qaγučin-ta* гэдэг нэр томъёо бүхий огноог монгол хэлний толиуд ба монгол зурхайн цаглавраас тайлбарлах арга үгүй байна.

Бид энэ өгүүлэлд *qaγučin* гэдэг нэр томъёог тайлбарлахдаа түүхийн сурвалж бичгийн доор дурдсан мэдээг үндэс болгож байна. Үүнд 1220-1221 онд Монгол оронд ирсэн хятад жуулчин Чжао Хуны бичсэн "Монгол-татаарын бүрэн тэмдэглэл (Мэн-да бэй-лу–Полное описание монголо-татар) гэдэг номд "тэд сар төгрөглөх бүрийг хараад л нэг сар болчихлоо гэдэг" (каждый раз они видят, что луна округлилась, они отсчитывают один месяц)⁹ гэж мэдээлсэн юм. Аль нэг сарын, жишээ нь 15-нд сар (луна) төгрөглөсөн бол тэр сар (месяц) төгсч маргааш нь 16-наас дараахи сарын нэгэн эхэлснээр бодож сар тоолох заншил эртний монголчуудад байсныг тэр хятад түшмэл хэлжээ. Чжао Хуны тэр ажиглалт бол Хубилай хаан, Их Монгол улсын нийслэлийг Хархорумаас Бээжинд шилжүүлж, монголчуудыг хятад цаглаварт албан ёсоор оруулснаас өмнөх үед хамаарч байгаа тул судалгааны үнэтэй мэдээ байна.

Сар төгрөглөх (дүгрэглэх)-ийг одоогийн монгол хүн, ардын дунд тогтсон билгийн тооллын нэр томъёогоор "арван таваны сар" гэдэг. Гэвч чухам нарийн дээрээ бол тэнгэрийн сар, сард хоёр удаа төгрөглөдөг нь мэдээж. Билгийн тооллын сар бүрийн 15-нд сарны гэрэлтэй хэсэг төгрөглөж, 30-нд гэрэлгүй хэсэг төгрөглөнө. Чжао Хуны тэмдэглэснээр сар төгрөглөх бүрд нэг сар дууслаа гэдгээр бол нэг сар нь 15 хоногтой аж. Чингээд нэг жилийг 24 сар болгон тоолдог балар эртний уламжлалыг 13-р зууны монголчууд хадгалж байсан бөгөөд тэр нь одоогийн монгол, төвөд, хятад зурхайн "хорин дөрвөн улирал" (24 сезона) буюу 24 бага сар гэдгийн уг сурвалж нь мөн бололтой.

Ингээд Чжао Хуны тэмдэглээг үндэс болгон эртний нүүдэлчдийн цаглаварыг сэргээвэл:

- 1) Сарны гэрэлтэй хэсэг төгрөглөх хүртэлхи 15 хоног бүхий нэг сар. Түүний нэрийг *Цагаан сар*¹⁰ буюу *Сүүн сар*¹¹ гэж нэрлэдэг байсан бололтой. Тийм сарын эхний 10-аад өдөр нь *Sined* (шинэ+олон тооны дагавар -д) гэдэг онцлох нэртэй. *Sara-yin sined* гэдэг нэр томъёог тайлбар тольд "аливаа сарын нэгэн шинээс хойш, нэг хэдэн өдрийг Сарын шинэдээр хэмээмэй"¹² гэдэг. Тэдгээр өдрүүдэд чухал үйлс, ялангуяа зөвзүгүү зөөлөн үйлсийг эхлэх заншилтай байсан. Одоогийн монгол (БНМУ) цаглаварт сарын эхний 15 өдрийг шинийн¹³ гэсэн тодотголтой бичсэн нь уламжлалтай тохирохгүй байна. Нэг анзааруштай юм бол тийм Цагаан сарын сүүлийн 5 өдөр (11-15-н), *sined* гэдэг үггүй байдаг нь болно. Яагаад гэвэл тэдгээр хоногт тэнгэрийн сар хэдийгээр улам томрон гэрэлтэх боловч чухамдаа нас хөгширч байгаа болохоор тэгж онцлохгүй байсан аж.
- 2) Сарны гэрэлгүй хэсэг төгрөглөх хүртэлхи 15 хоногтой нэг сар. Түүний нэрийг *Хар сар* буюу *Битүү сар* гэдэг байсан бололтой. 19-р зууны үеийн жүжгийн зохиолч Д. Равжаагийн "Саран Хөхөөгийн намтар" жүжгийн тайзны засалд "Зүүн зүгээс цагаан сар гарна. Удалгүй хар сар гарахад цагаан сар далд орно"¹⁴ гэсэн байдаг. Эртний монгол цаглаварт тийм Хар сарын эхний 10-аад өдөр нь *Qaučid* (*qaγučin*) (хуучин + олон тооны дагавар -д) гэсэн онцлох нэртэй. Хар сарын нас залуу байх тэдгээр *Sara-yin qaγučin* өдрүүдэд чухал үйлс, ялангуяа сөргүү хатуу үйлсийг эхлэх заншилтай байсан тул хааны засагийн бичиг тамгалахад тохиромжтой өдөр болохоор 13-14 зууны

⁶ Ligeti Louis, 1972, *Fragments...*, p. 141.

⁷ Клюкин И. А., 1926, с.23,25.

⁸ Дамдинсүрэн Ц., 1957, тал 41.

⁹ Мэн-да бэй-лу, 1975, с.49.

¹⁰ Цагаан сар гэсэн үг нь хожим цаглавар солигдоход *Шинэ жил, Шинэ жилийн эхний сар* гэсэн утга болсон бололтой.

¹¹ Үз Шэгдарсүрэн Ц., 2001, 34 тал.

¹² *Qorin nigetü tayilburi toli*, 1979, 535 tala.

¹³ Тэрбиш Л., 2002-2003, 70 тал.

¹⁴ Rabjai D., 1962, 63 tala.

монгол хаадын захидал бичгийн ихэнхи нь *qaučid* гэсэн онцлох тэмдэгтэй өдрүүдээр огногдсон байна. Хар сарын сүүлийн 5 (11-15-н) өдрүүдэд тэнгэрийн сар (хар хэсэг нь) улам томрох боловч *qaučid* гэсэн үгүй байдгийн учир нь Хар сар бас 11-нээс эхлэн хөгширч байгаа учраас тэр юм. Ингээд товчилбол эртний монгол цаглаварт ноцтой үйлсийг эхлэх онцлох тэмдэгтэй өдрүүд бол Сарын шинэд (тэнгэрийн сарны гэрэлтэй хэсэг арвидах) гэдэг эхний арваад өдөр, Сарын хуучид (тэнгэрийн сарны гэрэлгүй хэсэг арвидах) гэдэг эхний арваад өдөр байсан аж.

13-р зууны дундуур Хубилай хааны үеэс сарын өдрүүдийг нэгэнээс гучин хүртэл үргэлжлүүлэн тоолдог хятад зурхайн цаглаварт албан ёсоор шилжин ороход Хар сарын эхний хэсгийг хуучид нэртэйгээр онцлон үзэх ёс үгүй болж¹⁵ аажмаар мартагджээ. Монгол хэлний тайлбар толиудад хуучид (*qaučid*) гэдэг үгийг “сар, жилийн сүүлийн хувь”¹⁶ (сарын 20-ноос хойшхи өдрүүд Ж. Л.) гэж тайлбарладаг нь эртний *qaučid* /*qaučid* гэдгийн утгатай тохирохгүй. Тийнхүү нэг сарын хугацааг 15 хоног бүхий хоёр бага сар болгон хувааж тус бүрийн нь эхний арваад өдрийг (*sined*, *qaučid*) эрхэм сайн өдрөөр тооцох ёс бол эртний монголчуудын сарны шүтлэгтэй холбоотой сонин заншил юм.

13-р зууны дундуур Монголд ирсэн үеийн Францын жуулчин Плато Карпинийн тэмдэглэлд “тэд нар ямар нэгэн шинэ үйл хэргийг хийхэд ямагт сарын эхэнд буюу сарын дундуур эхэлж байдаг. Тэгэхдээ тэд нар сарыг Аугаа хаан гэж түүнд мөргөн даатгадаг юм. Тэд нар бол нарыг сарны эх гэдэг. Яагаад тэр вэ гэвэл сарны гэрэл нь нарнаас олж авч байгаа аж”¹⁷ гэж бичсэн юм. Тэнгэрийн сар нэгэнт “Аугаа их хаан” нэртэй эрхэм дээд шүтээн болохоор түүний гэрэлтэй ба гэрэлгүй хоёр хэсгийн томрох, багасах үзэгдлийг нэгэн адил төвшинд эрхэмлэн шүтэх нь ч зүй ёсны хэрэг байжээ. Плато Карпинийн ажигласан сарын эхний өдрүүд (новолуние) гэдэг бол бидний энд ярьж байгаа цагаан сарын *sined-te* гэсэн өдрүүдтэй тохирч, сарын дундуурхи өдрүүд (полнолуние) гэдэг нь хар сарын *qaučid-ta* гэсэн өдрүүдтэй тохирч байна.

Одоо өгүүллийн эхэнд дурдсан Ил хан Аргуны захидлын огноонд гарсан *junu terigün sara-yin jiryuyan qaučid-ta* гэдгийг “зуны тэргүүн сарын хоёрдугаар хэсэг – хар (хуучид) сарын зургаанд” буюу 30 хоногтой тоололд шилжүүлбэл (хуучид/хар сарын нэгнийг 16-наас эхлэн тоолно) зуны тэргүүн сарын 21-ний өдөр! аж. Нөгөө Өлзийт ханы захидалдхи *junu terigün sara-yin naiman qaučid-ta* гэдэг нь “зуны тэргүүн сарын хоёрдугаар хэсэг – хар (хуучид) сарын найманд” буюу 30 хоногтой тоололд шилжүүлбэл зуны тэргүүн сарын 23-ны өдөр юм байжээ.

Хубилай хааны үеэс эхлэн “*qaučid*” буюу хар сараар тоолох ёсыг хэрэглэхгүй болгож сарын ердийн тоололд шилжүүлсэн боловч бичиг номын зэргийн чухал үйлдлийг хуучин заншлынхаа ёсоор тэнгэрт хар сар арвидах (энэ үе бол сарны цагаан хэсэг баруун талаасаа багадсаар тал сар болох) үед үйлдсээр байсан нь соёл түүхийн олон баримтаас мэдэгдэнэ. Жишээ дурдвал, Буддийн шашны их цоморлиг Ганжуурыг Лигдэн хааны үед монгол хэлээр орчуулах эрхэм дээд үйлсийг “*arban nigedüger sayitur yaryusan-u qoyaduyar sirui luu jil-ün (1628) arban nigen sara-yin qorin nigen-eče ekilen qoyitu jil-ün (1629) jun-u dumdadu sara-yin tergel edür tegiiskebe*” гэдэг. Энд гарч буй “11 сарын 21” гэдэг бол угтаа *ebül-ün dumdadu sara-yin jiryuyan qaučid-ta* гэгч хар сарын эрхэм өдөр бөгөөд “зуны дундад сарын тэргэл өдөр” гэдэг бол *nigen qaučid-ta* гэгч - эртний монголчуудын онцгой эрхэмлэдэг өдөр болно.

Учир нь энэ өдөр тэнгэрийн сарны цагаан хэсэг төгрөг бөгөөд хар/хуучид сарын нэгэн эхэлж буй өдөр юм. Тийм өдрийг түүхийн сурвалж бичигт “*ulayan tergel edür*” гэдэг ба Аугаа хаан-Сар, чухам энэ ноцтой өдөр Их монгол улсын эзэн Чингис хааныг баруун гарт нь шагайн чинээ неж атган төрүүлж¹⁸, энэ өдөр Тайчуудын дөнгөнөөс мултлан аварч¹⁹ бас энэ өдөр Тэмүүжинийг түүний анд Жамухагаас хагацуулан²⁰ салаа замд оруулсан ажээ.

¹⁵ Хубилайн байгуулсан монголын Юан улсын төрийн бичиг – Дөрвөлжин үсгээр бичсэн баримтуудын эмхэтгэлд орсон 1276-1388 оны хоорондхи 12 бичгийн огноонд *qaučid* гэдэг үгийг нэг ч удаа хэрэглээгүй, зөвхөн *sined* гэдэг үгийг гурван удаа хэрэглэжээ. Yz Louis Ligeti, 1972, ‘phags-pa...

¹⁶ *Mongyol kelen-ü toli*, 1170 tala.

¹⁷ Plan Karpin, Viliyem Rübrüg, 1987, 64-65 tala.

¹⁸ МНТ, §59.

¹⁹ МНТ, §81.

²⁰ МНТ, §118.

НОМ ЗҮЙ

Дамдинсүрэн Ц., *Монголын уран зохиолын тойм*, Улаанбаатар.

Клюкин И. А., 1926, *Письмо Ульдзейту Ипхана к Филиппу Красивому, Едуарду I-му и прочим крестоносцам*, Труды Государственного Дальневосточного Университета, Серия VI, 2, Владивосток.

Louis Ligeti, 1972, *Monuments préclassiques I, XIII^e et XIV^e siècles*, in *Monumenta linguae mongolicae collecta II*, Akadémiai Kiadó, Budapest.

Louis Ligeti, 1972, 'phags-pa..., *Monuments en écriture 'phags-pa*, Budapest.

Louis Ligeti, 1972, *Fragments mongols de Berlin*, Akta Orientalia, T. XXIV(2).

Монголын нууц товчоо, 1990, Улаанбаатар

Mongol kelen-ü toli, 1997, 3142 tala, *Mongol kelen-ü toli*, Öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a, Čiyulultu qayaly-a qota.

Мэн-да Бэй-лу, 1975, "Полное описание монголо-татар", перевод с китайского введение, комментарий и приложения Н.Ц. Мункуева, Москва.

Plan Karpin, Viliyem Rübrüg, 1987, *Mongyol-du jiyulčilaysan temdeglel*, Öbürmongyol-un suryan kümüjil-ün keblel-ün qoriy-a.

Rabjai D., 1962, *Saran Köküge-yin namtar*, С. Damdinsürin keblel-dü beledkebe, Улаанбаатар.

Qorin nigetü tayilburi toli, 1979, 853 tala, *Qorin nigetü tayilburi toli*, Öbür mongyol-un mongyol kele udq-a jokiyal sudulqu yajar emkilebe.

Тэрбиш Л., 2002-2003, *Монгол зурхайн цаг тооны бичиг*, Улаанбаатар.

Цэдэнбал Я., 1999-2000, *XVII жарны Шарагчин Туулай жилийн монгол зурхайн цаг тооны бичиг*, Улаанбаатар

Шагдарсүрэн Ц., 2001, 304 тал, *Монголчуудын утга соёлын товчоон*, Улаанбаатар.